



ADDM

А Л Т А Н Д О Р Н О Д М О Н Г О Л

ТУХАЙЛСАН ЗОРИЛГО БҮХИЙ КОЙН

WHITEPAPER

МЭДЭГДЭЛ

Энэхүү баримт бичиг нь зөвхөн мэдээллийн чанартай бөгөөд хөрөнгө оруулагчдад ADMC койны үйл ажиллагаа, хэтийн төлөвлөгөө, койны онцлог зэргийг танилцуулах зорилготой болно.

Уг танилцуулга дээрх тоо баримт, мэдээлэл болон түүний агуулга нь ADMC койны худалдан авах санал, захиалга хийх уриалга биш ба хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагуудад хөрөнгө оруулалтын зөвлөгөө болох бичиг баримт биш болно.

"Алтан Дорнод Монгол" ХХКомпаний гаргаж буй ADMC койн нь крипто хөрөнгийн зах зээлд өөрийн өнөөгийн үйл ажиллагаа болон ирээдүйд хэрэгжүүлэх төслүүд, бодит хөрөнгөнд суурилсан, хувьцаанд хөрвөх боломжтой, койн гаргагч буцаан худалдан авах нөхцөл бүхий шинэ төрлийн бүтээгдэхүүн болох талаарх танилцуулга юм.

"Алтан Дорнод Монгол" ХХК, түүний төслийн баг ADMC койн гаргахдаа койн эзэмшигчийн эрсдлийг бууруулах дээрх шинжүүдээс гадна нэгдсэн бодлого, засаглалыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөө энэ танилцуулгад багтаасан.



ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

"Алтан Дорнод Монгол" ХХК-ийн гаргаж буй ADMC койн нь уул уурхайн томоохон төсөл, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд дэлхийд үнэлэгдэх, үнэ цэнэтэй бүтээн байгуулалтыг хамтран гүйцэтгэх боломжийг койн эзэмшигч та бүхэнд олгож байна.

"Алтан Дорнод Монгол" ХХК нь олонд танигдсан, нэр хүндтэй, Монгол улсын томоохон компаниудын нэг. Үйл ажиллагаа явуулах хугацаандаа зөвхөн уул уурхайн салбарт 300 гаруй тэрбум төгрөгний татварыг улсад төлсөн. Барилгын салбарт нийтдээ 100'000 метр квадрат талбай бүхий оффис, буудал болон хувийн орон сууц нийлсэн объектын бүтээн байгуулалт хийсэн. Бид ойрын хугацаанд дээрх тоог 82'000 метр квадратаар нэмэх зорилготойгоор үл хөдлөх хөрөнгийн төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. Мөн IT салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийж, Монголдоо анхдагч блокчейнийг Дундад Азийн зах зээлд гаргахаар бэлдэж байна.

Тус компанийн хөрөнгө оруулалт хийсэн IT компани одоогоор 100 гаруй программ хөгжүүлэгчдийг эгнээндээ нэгтгэсэн бөгөөд цаашдаа үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр ажиллаж байна.



КОЙН ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

ADM группын "Алтан Дорнод Монгол" компани 1997 онд байгуулагдсан бөгөөд алтны хайгуул олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын хэмжээний томоохон уул уурхайн компаниудын нэг юм.

2011 оны есдүгээр сард үндэсний хөрөнгө оруулагчид татвар болон бусад өр зээлийн хамт "Алтан Дорнод Монгол" ХХК-ийг хамаарал бүхий бусад компаниудтай нь худалдан авч, 300 орчим сая долларын татвар, банк, ААН байгууллагуудын өр төлбөрийг барагдуулсан.

Алт олборлох үндсэн үйл ажиллагааг явуулахдаа байгаль-экологийн асуудлыг эн тэргүүнд тавьдаг. Байгалийн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 2000 га талбайг нөхөн сэргээсэн.

"Алтан Дорнод Монгол" компани нийтдээ 3500 ажлын байр бий болгосон.

Мөн үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээний салбарт олонд танигдсан брэнд Корпорэйт зочид буудлын сүлжээг үүсгэн байгуулсан.

ADM



ADM ГРУПП
АЛТАН ДОРНОД МОНГОЛ

ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН БОДЛОГО, АЛСЫН ХАРАА

ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН НЭГДСЭН БОДЛОГО

БЛОКЧЕЙН ТЕХНОЛОГИ,
КОЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

САНХҮҮЖИЛТ,
ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ХАНШИЙН
УДИРДЛАГА

ИЛ ТОД БАЙДАЛ,
САЙН ЗАСАГЛАЛ

ТӨСЛИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

АДМ

Гадаадын зах зээлд

Дотоодын зах зээлд

УУЛ УУРХАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Уул уурхайн томсоохон нөөцтэйд тооцогддог Африкт алт олборлолтын төсөлд хөрөнгө оруулалт хийж, үндэстэн дамнасан уул уурхайн компанийг бий болгоно. Анхан шатны гэрээ хэлэлцээр, харилцан ойлголцох санаамж бичиг зурагдсан төслүүддээ хөрөнгө оруулна.

BLOCKCHAIN

Монголд улсад эрчимтэй хөгжиж байгаа мэдээллийн технологийн салбарт Алтан Дорнод Монгол компани хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд монголын залуучуудын бүтээсэн блокчейн экосистемийг Дундад Азид болон дэлхийд гаргах зорилготой.

ХАА, ГАЗАР ТАРИАЛАН

Дэлхийд хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт өгөөжөөрөө тэргүүлэгч Уругвай улсад албан ёсны харилцаа холбоон дээрээ тулгуурлан, төсөлд хөрөнгө оруулалт хийнэ.

УУЛ УУРХАЙН САЛБАРТ

"Алтан Дорнод Монгол" ХХК-ийн хэрэгжүүлж буй алтны хайгуулын ажил эхэлсэн төслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Одоогоор барилгын ажил нь 50 хувийн гүйцэтгэлтэй 40'000 болон 42'000 кв метр талбайтай хотын АДА зэрэглэлийн бүсэд байршилтай барилгын хоёр төслийг худалдан авч, олон улсын жишигт нийцсэн таван одтой зочид буудал, бизнесийн төвийг байгуулна.

ЛОКЧЭЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

Блокчэйн технологи нь бизнесийн бүхий л салбарт ашиглагдаж, дижитал шилжилтийн үйл явцыг дэлхий даяар хурдасгаж байна. Блокчэйний аюулгүй, ил тод байдлыг хангаж буй үндсэн шинж чанар нь бизнесийн бүхий л талбарт ашиглах боломжийг нээж өгдөг.

Төслийн баг блокчэйн технологийг уул уурхай, үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуй, төрийн байгууллага гэх дөрвөн үндсэн салбарт суурилан хөгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ нь ADMC койны төслийн үндсэн үйл ажиллагааг дэмжихээс гадна урт хугацаандаа бие даасан платформ, бизнесийн чиглэл болон өргөжих зорилготой юм.

УУЛ УУРХАЙ САЛБАРТ БЛОКЧЭЙН АШИГЛАХ НЬ

Уул уурхайн салбарт блокчэйн технологийг нэвтрүүлэхдээ бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн, үйлдвэрлэлт, тээвэрлэлт, ашиглалт хүртэлх процессийг бүхэлд нь технологижуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Томоохон уул уурхайн компаниуд нь мэдээллийн солилцооны удаашрал, ойлгомжгүй байдал, хоорондын уялдаа холбоогүй үйл ажиллагаанаас шалтгаалан жил бүр асар их хэмжээний зардал гаргадаг.

Манай баг уул уурхайн салбарт хоёр төрлийн үйл ажиллагааг блокчэйнд суурилсан байдлаар хөгжүүлэхийг зорьж байгаа бөгөөд энэ нь цаасанд суурилсан уламжлалт арга барилыг бүхэлд нь өөрчлөх, уул уурхайн оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, итгэлцэл үүсгэх боломжоор хангах юм.

Мөн уул уурхайн салбарын шилэн байдлыг нэмэгдүүлэх зорилгоор блокчэйнд суурилсан онлайн платформ хөгжүүлэлт хийгдэнэ.


Уул уурхайн олборлолт хийдэг компаниас эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртэл оролцож буй бүхий л талуудыг хамарсан консорциум үүсгэж, процесс бүхэлдээ блокчэйнд суурилсан тохиолдолд уул уурхайн бүтээгдэхүүнийг олон улсад гаргах, гарал үүслийн баталгаажуулалт, итгэлтэй байдал зэрэгт эерэг өөрчлөлт авч ирэх боломжтой.



ТҮРЭЭСИЙН БИЗНЕСТ БЛОКЧЭЙН АШИГЛАХ НЬ


Түрээсийн бизнес гэдэгт оффис түрээсийн үйлчилгээ, объект түрээс, өрөө түрээс гэх зэрэг үл хөдлөх хөрөнгөнд суурилсан бүхий л үйлчилгээг багтаан үзнэ. Энэ үйлчилгээнд Smart contract ашиглан түрээслэгч, түрээслүүлэгчийн хооронд үүсэх харилцааг блокчэйн технологид суурилсан платформ хөгжүүлэх байдлаар шийдвэрлэнэ. Блокчэйн технологийн үндсэн давуу тал болох хуурамч мэдээлэл дамжих эрсдэлээс сэргийлэх, нууцлалыг дээд төвшинд хадгалах боломжийг ашиглан мэдээллийн нэгдсэн дата бааз үүсгэх байдлаар платформыг хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Блокчэйн платформ ашиглан түрээсийн үйлчилгээг үзүүлэх нь цаг хэмнэх, зардал бууруулах, давхардлыг арилгах, ажилчдын тоог бууруулах, ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлэх зэрэг өндөр ач холбогдолтой. Хэрэглэгч талаас түргэн шуурхай үйлчилгээ авах, залилан, хууран мэхлэлтээс сэргийлэгдэх, баталгаат эх сурвалжаас мэдээлэл авах боломжоор хангагдана.



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ БЛОКЧЭЙН АШИГЛАХ НЬ

Монгол улсын хөдөө аж ахуйн салбарт блокчэйн хөгжүүлэх боломж хамгийн өндөр тооцогддог нь Монгол улсын уламжлалт мал аж ахуй болон газар тариалангийн үйл ажиллагаатай холбоотой. Блокчэйн тус салбарт хөгжүүлэх нь хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, худалдан авагч, бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаа, нууцлалыг нэмэгдүүлэх боломжоор хангах юм. Мөн иргэдэд эрүүл мэндийн шаардлагыг хангасан хүнсний бүтээгдэхүүн мөн эсэхийг блокчэйн технологи ашиглан бүрдүүлнэ.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ADM




КОЙНЫ ТАНИЛЦУУЛГА


ADMC ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Койны нэр	Altan Dornod Mongol Coin	Койны стандарт	BEP20
Койны тиккер	ADMC	Нийт гаргах койны тоо хэмжээ	495,000,000,000
Койны хаяг	0x7CaE01C241213C05036A629FDDb195d35141f566	Койны нэгж үнэ	1 төгрөг
Койн гаргагч	"Алтан Дорнод Монгол" ХХК	Олборлолт	Олборлолт буюу майнинг хийх боломжгүй

КОЙНЫ БҮТЭЦ



ДОТООДОД САНАЛ БОЛГОХ КОЙНЫ ЗАРЦУУЛАЛТ



ХАНШИЙН УДИРДЛАГА

ADMC койны ханшийн удирдлага нь Blockchain технологийн хөгжүүлэлтээр дэмжигдсэн үнэ цэнэ, төслийн удирдлагын үр ашигт суурилсан эрэлт нийлүүлэлтийн зарчимд суурилж урт хугацааны тасралтгүй үнэ цэнийг бий болгох, stable койн бий болгох стратегид үндэслэнэ.

Энэхүү суурь стратегиас гадна дараах механизмыг ханшийн удирдлагад ашиглана.

INSIDER

Төслийн эзэмшигчид өөрсдийн 10 хувийг 2 жилийн хугацаатай түгжинэ. Төслийн хэрэгжилтээс шалтгаалж тухайн үед гарах нөхцөлийг тодорхойлно.

STRATEGIC INVESTOR

Томоохон хөрөнгө оруулалт хийх боломжийг зөвшөөрнө. Хөрөнгө оруулагчид цуврал байдлаар төслийн хэрэгжилт, койны хөгжүүлэлт, зах зээлийн тэлэлттэй уялдан гарах шалгуур тавина.

BURN

Ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор 10 хувийг нөөцлөнө. Шаардлагатай тохиолдолд нийлүүлэлтийг хязгаарлах зорилгоор койныг устгалд оруулна.

DEFI LIQUIDITY

Хөрвөх чадварыг хангах сан байгуулна.

1

Койны ханшийн өөрчлөлт

ADMC койн арилжаалагдаж буй бирж дээр өөрийн оруулсан хөрөнгө оруулалтыг зарах, эргэн хөрөнгө оруулалт хийх байдлаар ханшийн өөрчлөлтөөс хамааран ашиг хүртэх

2

Хөрөнгө оруулалтын өгөөж

ADMC койны дотоодын болон гадаад төсөл хөтөлбөрүүдэд оруулсан санхүүжилтийн өгөөж, төсөл хөтөлбөрүүдийн амжилттай байдлаас хамааран хөрөнгийн өгөөж хүртэх

3

Ногдол ашиг авах

ADM цахим биржийн үйл ажиллагааны ашгаас болон койн эзэмшигч өөрийн эзэмшлийн койныг хувьцаанд хөрвүүлснээр төслийн ашгаас хүртэнэ.

ADMC КОЙНЫ ДАВУУ ТАЛ

ADMC КОЙНЫ ДАВУУ ТАЛ

Койны зарцуулалт бодит төсөл, хөтөлбөрүүдэд чиглэнэ. "Алтан Дорнод Монгол" ХХК нь төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийхдээ хөрөнгө оруулалтын багц үүсгэх байдлаар ажиллана. Мөн уул уурхай болон, Үл хөдлөх хөрөнгийн салбарын төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийн эрсдэлийг тараан байршуулна.

Багц үүсгэх төслүүд, түүний төлөвлөлт, хэрэгжилтийг төслийн цагалбарын дагуу төслүүдийг нээлттэй танилцуулна. Холбогдох тайлангуудыг ил тод байдлын хүрээнд тогтмол хүргэж ажиллана.

"Алтан Дорнод Монгол" ХХК нь зочид буудлын салбарын туршлагадаа тулгуурлан Улаанбаатар хотын "ААА" зэрэглэлийн бүсэд байрших үл хөдлөх хөрөнгийн болон уул уурхайн төслүүдийн хөрөнгө оруулалтууд нь дотоодын төсөлд багтаж байна.

БОДИТ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН



i ADMC койны бусад крипто хөрөнгө болон койнуудаас ялгагдах гол онцлог нь зарцуулалтын төлөвлөгөө болон түүний ил тод байдлыг дээд хэмжээнд ханган ажиллахад оршино.

ADMC КОЙНЫ ДАВУУ ТАЛ

Крипто валют, крипто хөрөнгө, койн нь өндөр эрсдэл дагуулдаг болохыг харгалзан ADMC койн эзэмшигчдын эрсдэлийг боломжит хамгийн доод төвшинд барих, "Алтан Дорнод Монгол" ХХК болон койн эзэмшигчдийн хооронд итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор койн эзэмшигчийг эрсдэлээс хамгаалах боломжоор хангана. ADMC койн нь хоёрдогч зах зээлд арилжаалагдсанаас хойш гурван сарын дотор койн эзэмшигч хүсэлт гаргавал "Алтан Дорнод Монгол" ХХК анхны үнээр худалдан авна.

КОЙН ЭЗЭМШИГЧИЙГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛСАН




ADMC КОЙНЫ ДАВУУ ТАЛ

Блокчэйн хөгжүүлэлт, крипто биржийн үйл ажиллагааны ашгаас койн эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилна.

Койн эзэмшигч өөрийн эзэмшлийн койныг хувьцаанд хөрвүүлснээр хувьцааны ногдол ашиг хүртэх боломжтой.

3

НОГДОЛ АШИГ



ADMC КОЙНЫ ДАВУУ ТАЛ

Урт хугацаанд ADMC койны хөрөнгө оруулах төслүүдийн хувьцаа болон "Алтан Дорнод Монгол" ХХК-ийн гаргаж буй хувьцаанд койн эзэмшигчийн эзэмшилд буй койн анхны үнээр хөрвөх боломжтой байна.

НЭРЛЭСЭН ҮНЭЭР ХУВЬЦААНД ХӨРВӨХ

4



ADMC КОЙНЫ ДАВУУ ТАЛ

"Алтан Дорнод Монгол" ХХК нь ADMC койн эзэмшигчтэй түншлэлийн зохистой харилцаатай байхыг ямагт эрмэлзэх ба ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлд дараах байдлаар ажиллахаар төлөвлөсөн болно.

- Койн гаргалт, арилжаа, үйл явдлын мэдээллийг сар бүр койн эзэмшигчдэд хүргэнэ.
- Урт хугацааны төслүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, санхүүгийн байдал гэх зэрэг хөрөнгө оруулалттай холбоотой чухал мэдээллүүд багтаасан ADMC койн эзэмшигчид хүргүүлэх тайланг улиралд 1 удаа өгнө.
- Биржийн үйл ажиллагааны тайланг улиралд 1 удаа өгч ажиллана.
- Төсөл хөтөлбөр, компанийн үйл ажиллагаанд жилд 1 удаа олон улсад магадлан итгэмжлэгдсэн нэр хүндтэй компаниар аудит хийлгэнэ.

5

ИЛ ТОД БАЙДАЛ



ADM

ТӨСЛИЙН БАГИЙН
ГИШҮҮДИЙН ТАНИЦУУЛГА



Тордай ГАНБОЛД

"Алтан Дорнод Монгол" ХХК -ийн Хувь нийлүүлэгч

Дорнын Бүгд Найрамдах Уругвай улсын
өргөмжит Консул

Төгссөн сургууль:

- Гадаад хэлний дээд сургууль,
- ХБНГУ маркетинг менежмент,
- Санхүү эдийн засгийн дээд сургууль

Мэргэжил: Санхүүч, эдийн засагч

Хэл: Орос, Франц, Герман, Англи

Амжилттай хэрэгжүүлсэн төслүүд:

- 2001-2007 он хүртэл Монгол Улсын газар тариалангийн салбар бүрэн уналтад орсон үед улаан буудайг ОХУ-аас нийлүүлж дангаараа зах зээлийн 60 хувийг хангаж байсан
- 2006, 2009, 2013 онд Корпорейт зочид буудлын гурван салбар, 1200 суудалтай концертын их танхим байгуулсан
- 2006-2009 онд Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гүйцэтгэх захирлаар ажиллаж үйлдвэрлэлийн хүчин чадлыг 20-88 хувьд хүргэж, Монгол Улсын хамгийн том төмрийн хүдрийн Төмөртэйн ордыг Хятадын компаниас авч, 100 хувь төрийн үйлдвэрийн харьяа болгож чадсан
- 2011 онд Монголын хамгийн том алтны хайгуул, олборлолтын үйл ажиллагааг эрхэлж байсан "Алтан Дорнод Монгол" ХХК-ийг ОХУ-ын компаниас худалдаж авч, олборлолт хийгээд орхисон их хэмжээний газарт байгалийн нөхөн сэргээлт хийж, өр төлбөрүүдийг нь барагдуулсан
- 2013 онд Монголын Алт Үйлдвэрлэгчдийн холбоог байгуулж дотоодын компаниудыг нэгтгэн, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж жилдээ 3 тн тушаагддаг байсан алтны хэмжээг 20 тн-д хүргэх ажлыг зохион байгуулсан
- 2015-2019 онд Шамбалла цэцэрлэгт хотхоныг барьж ашиглалтад оруулав



Лхагвадорж ӨНӨР

"Алтан Дорнод Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Менежментийн ухааны доктор (Ph.D)

"Төгском" ХХК-ийн гүйцэтгэх захирал
"Сөүл Групп" ХХК, "Линкс Поверкор" ХХК
уудад Бизнес хөгжлийн захирлын албан тушаал хашиж
байсан.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, НҮБ-ын "Даян дэлхийн гэрээ"/UN Global Compact/-ний Монгол дахь сүлжээ болон Дэлхийн Эдийн Засгийн Форумын "Авилгын эсрэг түншлэл"-ийн Монгол дахь сүлжээний зохицуулагчаар 10 гаруй жил ажилласан туршлагатай



Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН

ADMC Төслийн удирдагч

Санхүүч, эдийн засагч

Албан тушаал

- 1995 оноос үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулалт, банк санхүүгийн чиглэлээр ажиллаж, 1997 оноос хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээлийн чиглэлээр их дээд сургуульд багшилж байна.

Боловсрол, зэрэг:

- Эдийн засагч,
- санхүүч,
- эрх зүйч
- Үнэт цаасны зах зээл хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн
- Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн багш, дэд профессор
- **Судалгааны ажил, ажлын туршлага:** Санхүүгийн зах зээл, Макро эдийн засаг, Төсөв, мөнгөний бодлого
- Үл хөдлөх хөрөнгө, уул уурхайн салбарын төслүүдэд удирдагч, шинжээч, зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай



Цэнддаваа ДАВААДОРЖ

Төслийн эдийн засаг, санхүүгийн ахлах зөвлөх

Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) профессор

Боловсрол

- МУИС, ЭЗС, Монгол –Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал
- МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн бакалавр
- Японы Шигагийн Их Сургуулийн мастер
- Японы Киотогийн Их сургуулийн доктор

Судалгааны ажил:

- Third Part Evaluator on Baganaur and Shivee-Ovoo Coal Mine Development Project (I)(II)-2007 он
- “Монголчуудын аж ахуйн судлал”, ШУА-ийн грант төсөл
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлалыг боловсронгуй болгох нь



Францэйш ГАБРИЭЛ

ADMC Блокчейн зөвлөх

Боловсрол

- Франц улсын Тоулоусын их сургууль - Эдийн засаг, хэл шинжлэлийн бакалавр
- Английн Ньюкастлын их сургууль - Эрасмусын хөтөлбөр
- Япон улсын Олон улсын Христын их сургууль
- Франц улсын Тоулоусын их сургууль - Олон улсын эдийн засгийн магистр

Судалгааны ажил:

Азийн улсуудад блокчэйн технологи нийлүүлэх чиглэлд мэргэшсэн туршлагатай энтерпрэнэр, бөгөөд дэлхийн хэмжээний олон амжилттай төслүүдэд оролцсон. ADCM төслийг олон улсын зах зээлд гаргах ажилд хамтран оролцоно.



Жамъянсүрэн ОЙМАНДАХ

ADMC Төслийн зөвлөх

Олон улсын хуульч (P.J.D)

“Корпорейт Комплаенс” Менежмент хууль, менежментийн консалтинг компанийн Гүйцэтгэх захирал 20 гаруй жил олон улсын худалдаа, санхүү, уул уурхай, эрчим хүч болон газрын тосны салбарт ажилласан туршлагатай.

Амжилттай ажилласан төслүүд:

- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн төслүүд
- Азийн Хөгжлийн Банкны төслүүд
- Vestas Wind Turbine Pte.
- HSBC banking
- Baker & McKenzie law firm
- Rio Tinto (Oyu Tolgoi & SouthGobi Sands)



Төрболд БАТ-ОРГИЛ

ADMC төслийн гадаад харилцааны зөвлөх

Хуульч, эрх зүйч

Албан тушаал:

- “Дачен Дентонс хуулийн фирмийн Ахлах зөвлөх

Мэргэжил:

- Төгссөн сургууль: АНУ-ын Жэймс Мэдисоны Их сургууль- Бизнесийн удирдлагын мастер
- АНУ-ын Жэймс Мэдисоны Их сургууль -Улс төр судлалын Төрийн захиргааны мастер



Ганбат АНАРХҮҮ

ADMC төслийн медиа зөвлөх

Албан тушаал:

- "Октопус консалтинг" компанийн Гүйцэтгэх захирал
- "Амжилтаа ахиулая" ТББ-ын тэргүүн
- "24/7 спортс" компанийн үүсгэн байгуулагч

Боловсрол:

- Итали улсын Генуя хотын их сургууль
- Тайваны их сургууль
- Отгон тэнгэр их сургууль



Ишгалдан БЯМБАХҮҮ

ADMC Төслийн байгаль орчин, ногоон хөгжлийн зөвлөх

Байгалийн шинжлэх ухааны доктор /Ph.D/

Албан тушаал:

- "Би Жи Эм Дистрибьюшн" ХХК-ийн захирал

Боловсрол:

- МУИС-Физик электроникийн сургууль-Бакалавр
- Япон Улсын Цукубагийн Их сургууль-Магистр
- Япон Улсын Цукубагийн Их сургууль -Доктор



Гонгорсүрэн МӨНХ-ЭРДЭНЭ

ADMC төслийн технологийн багийн ахлах

Албан тушаал:

- "Төгском" ХХК-ийн үүсгэн байгуулагч, Технологи хариуцсан захирал

Боловсрол:

- ШУТИС ХоМТС-ийн бакалавр
- VMware VD-Administrator, Microsoft Solutions Expert, EC-Council Certified Ethical Hacker, Linux Foundation-Kubernetes Certified Administrator зэрэгхөтөлбөрт хамрагдан мэргэшсэн

Амжилттай ажилласан төсөл:

- Мост Финтек MostMoney төсөл
- Google, Apple компанийн хамтарсан Exposure notifications төслийг Монголд улсад нэвтрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн.



Бүрэндэлгэр БҮРЭНХҮҮ

ADMC төслийн технологийн багийн гишүүн

Мэргэжил:

- Програм хангамжийн инженер

Боловсрол:

- Лондонгийн Их сургууль /Кьюн Мэри-/Компьютерийн Шинжлэх ухаан, Бизнесийн удирдлагын бакалавр



Өнөрсайхан ХИШИГБАЯР

ADMC төслийн технологийн багийн гишүүн

Албан тушаал:

- Төгском ХХК-д Ахлах хөгжүүлэгч

Амжилттай ажилласан төсөл:

- Татварын ерөнхий газар, Гааль татвар санхүүгийн мэдээллийн технологийн төв зэрэг монгол улсын санхүүгийн салбарын системүүдийн хөгжүүлэлтийг хийж байсан туршлагатай.



Баасангарав МӨНХТОГТОХ

ADMC төслийн технологийн багийн гишүүн

Төгссөн сургууль:

- ШУТИС-ийн Мэдээлэл холбоо, технологийн сургууль-Бакалавр
- БНТУ-ын Фатихын Компьютерийн Шинжлэх ухааны сургууль-Магистр

Амжилттай ажилласан төсөл:

- Монгол Улсын Татварын удирдлагын нэгдсэн систем, Татварын тайлангийн системийг амжилттай хийж гүйцэтгэсэн



Чинбат БИЛЭГСАЙХАН

ADMC төслийн технологийн багийн гишүүн

Мэргэжил:

- Программ хангамжийн инженер

Боловсрол:

- МУИС-ийг Программ хангамжийн инженер мэргэжлээр төгссөн



Батсайхан ОРГИЛ

ADMC төслийн технологийн багийн гишүүн

Мэргэжил:

- Программ хангамжийн инженер

Боловсрол:

- Монгол улсын их сургууль Программ хангамжийн инженер мэргэжлээр төгссөн

ADM



ADM ГРУПП
АЛТАН ДОРЖИД МОНГОЛ

tugscom



Corporate
HOTEL & CONSULTING CENTER
ULANBAATAR



@ADMCoinmn



72109999